



**МОНГОЛ УЛСЫН УУЛ УУРХАЙ,  
ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМ**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,  
Нэгдсэн үндэстний гудамж 5/1, Засгийн газрын II байр.  
Утас: 26-35-06, Факс: (976-11) 31-81-69,  
<http://www.mmhi.gov.mn>

2020.12.08 № 10/3006  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**АШИГТ МАЛТМАЛ, ГАЗРЫН  
ТОСНЫ ГАЗРЫН ДАРГА  
Х.ХЭРЛЭН ТАНАА**

Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2020 оны 12 дугаар сарын 07-ны өдрийн А-311 тоот тушаалаар батлагдсан “Уул уурхай, хүнд үйлдвэрийн яаманд Ашигт малтмал, газрын тосны газар болон Үндэсний геологийн албанаас мэдээ, тайлан ирүүлэх журам”-ыг хавсралтаар хүргүүлж байна.

Журмын хэрэгжилтийг ханган ажиллаж мэдээ, тайлангаа заасан хугацаанд ирүүлж байхыг үүгээр мэдэгдэж байна.

Хавсралт 7 хуудастай.

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ ҮНЭЛГЭЭ,  
ДОТООД АУДИТЫН ГАЗРЫН  
ДАРГА

Ц.ОДХҮҮ



08 2739



МОНГОЛ УЛСЫН  
УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН САЙДЫН ТУШААЛ

2020 оны 12 сарын 07 өдөр

Дугаар А-311

Улаанбаатар хот

Журам батлах тухай


Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2, Монгол Улсын Яамны эрх зүйн байдлын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.3, Статистикийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.3 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:


1. Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд салбарын үйл ажиллагаатай холбоотой бодлого боловсруулах, үйл ажиллагааны төлөвлөлт, удирдлага зохицуулалтын ажилд шаардлагатай албан ёсны мэдээ, тайланг Ашигт малтмал, газрын тосны газар, Үндэсний геологийн албанаас ирүүлэх журмыг 1 дүгээр хавсралтаар, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яаманд Ашигт малтмал, газрын тосны газар болон Үндэсний геологийн албанаас мэдээ, тайлан ирүүлэх хуваарь, хариуцах нэгжийг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Энэ тушаалын 2 дугаар хавсралтаар батлагдсан мэдээ, тайланг хуваарийн дагуу гаргаж, тогтоосон хугацаанд ирүүлж байхыг Ашигт малтмал, газрын тосны газар /Х.Хэрлэн/-т, Үндэсний геологийн алба /О.Чулуун/-д, ирүүлсэн мэдээ, тайланг нэгтгэн боловсруулж яамны удирдлагад танилцуулж байхыг Судалгаа, хөрөнгө оруулалтын газар /Э.Батболд/-т тус тус үүрэг болгосугай.

3. Тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар /Ц.Одхүү /-т даалгасугай.

4. Энэ журам батлагдсантай холбогдуулан Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2016 оны А/60 тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.





## **Уул уурхай, хүнд үйлдвэрийн яаманд Ашигт малтмал, газрын тосны газар болон Үндэсний геологийн албанаас мэдээ, тайлан ирүүлэх журам**

### **Нэг. Нийтлэг үндэслэл**

1.1. Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны харьяа агентлагууд болох Ашигт малтмал, газрын тосны газар, Үндэсний геологийн алба (цаашид агентлагууд гэх)-наас ирсэн мэдээ, тайланг үндэслэн салбарын нийгэм, эдийн засгийн үзүүлэлтэд дүн шинжилгээ хийх, хөгжлийн хэтийн төлвийг тодорхойлох, танилцуулах, мэдээллийн арга зүйг боловсронгуй болгох, нэгдсэн мэдээллийн сантай болох харилцааг энэхүү журмаар зохицуулна.

1.2. Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам (цаашид яам гэх) хууль тогтоомж, Засгийн газрын болон сайдын шийдвэрийн хэрэгжилтийг хангах зорилгоор биелэлтийг гаргуулах, салбаруудын үйл ажиллагааны мэдээ, мэдээлэл, тайлан болон төлөвлөлтийн саналыг авах зорилгоор агентлагуудын удирдлагатай албан бичгээр болон цахим хэлбэрээр (яаралтай тохиолдолд) харилцана.

1.3. Салбарын бодлого шийдвэрийн биелэлт, үйл ажиллагаатай холбогдсон бодлого боловсруулалт болон төлөвлөлтийн санал, мэдээ, мэдээлэл, тайланг заавал агентлагуудын дарга эсвэл орлогч даргаар хянуулж яаманд хүргүүлнэ.

1.4. Мэдээ, тайлангийн баталгаажуулалтыг мэдээ, тайлан боловсруулсан албан тушаалтан, холбогдох хэлтсийн дарга, орлогч дарга, газрын дарга хийнэ.

1.5. Яам нь удирдах дээд байгууллага, холбогдох бусад байгууллагаас хугацаа зааж ирүүлсэн яаралтай албан бичгийн хариуг бэлтгэхэд шаардлагатай мэдээллийг агентлагуудын удирдлагатай шууд холбогдон цахим хэлбэрээр авч болно.

### **Хоёр. Мэдээ ирүүлэх, хүлээн авах**

2.1. Ашигт малтмал, газрын тосны газрын Хяналт, шинжилгээ, үнэлгээ, статистикийн хэлтэс, Үндэсний геологийн албаны Төрийн захиргааны удирдлагын хэлтэс нь энэхүү журмын хоёрдугаар хавсралтаар батлагдсан мэдээ, тайланг ирүүлэх хуваарийг баримтлан нэгтгэн цахим хэлбэрээр ирүүлнэ.

2.2. Яамны Судалгаа, хөрөнгө оруулалтын газар нь сайдын эрхлэх асуудлын хүрээний бодлого боловсруулах, удирдамжаар хангахад шаардлагатай тооцоо, судалгаа, мэдээ, мэдээллийг тогтоосон журмын дагуу харьяа агентлагуудаас авч салбарын эдийн засгийн үзүүлэлтийн талаарх

мэдээллийн танилцуулга боловсруулж удирдлага, холбогдох газруудад цахим хэлбэрээр танилцуулна.

2.3. Мэдээ тайлангийн үнэн зөвийг шалгах, илэрсэн зөрчил, дутагдалыг арилгуулах арга хэмжээг авах замаар мэдээллийг ирүүлэх хугацаа, мэдээллийн чанарт яамны Судалгаа, хөрөнгө оруулалтын газар болон Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар дүн шинжилгээ хийж үнэлнэ.

2.4. Агентлагуудын чиг үүргийн хэрэгжилтийн үнэлгээний үзүүлэлтийг дүгнэхдээ энэхүү журмын 2.3-д заасан үнэлгээг үндэслэн дүгнэнэ.


### **Гурав. Хариуцлага**

3.1. Энэхүү журмыг зөрчсөн албан тушаалтанд тухайн зөрчлийн шинж байдал, түүнийг анх буюу давтан үйлдсэнийг харгалзан Төрийн албаны тухай хуулийн 48 дүгээр зүйлд заасан сахилгын шийтгэл ноогдуулна.

### **Дөрөв. Бусад зүйл**

4.1. Энэхүү журмыг батлагдсан өдрөөс эхлэн мөрдөнө.

Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2020 оны 12-р сарын 01 өдрийн 11 тоот тушаалын 2 дугаар хавсралт



**УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМАНД АШИГТ  
МАЛТМАЛ, ГАЗРЫН ТОСНЫ ГАЗАР,  
ҮНДЭСНИЙ ГЕОЛОГИЙН АЛБАНААС МЭДЭЭ, ТАЙЛАН  
ИРҮҮЛЭХ ХУВААРЬ**

№	Мэдээллийн нэрс	Хугацаа	Яамны аль газар, хэлтэст ирүүлэх	АМГТГ-ын хариуцсан хэлтэс	ҮГА-ны хариуцсан хэлтэс
1	Ашигт малтмал, газрын тосны газар, Үндэсний геологийн албаны 7 хоногийн ажлын тайлан	7 хоног бүрийн 5 дахь өдрийн 15 цагаас өмнө	ТЗУГ, ХШУДАГ	ТЗУХ	ТЗУХ
2	Хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн хайгуулын ажлын төлөвлөгөө, жилийн тайлангийн мэдээ.	Дараа сарын 05-ны дотор	СХОГ, ГБГ	АМХХ	ГСХ, ЭБСЭЗТХ
3	Голлох ашигт малтмалын олборлолт, экспортын мэдээ (төлөвлөгөө, гүйцэтгэл)	7 хоног бүрийн 5 дахь өдрийн 15 цагаас өмнө, дараа сарын 05-ны дотор	СХОГ, ТЗУГ	УУУТХ	-
4	Улсын төсөвт төвлөрүүлсэн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэлийн мэдээ	7 хоног бүрийн 5 дахь өдрийн 15 цагаас өмнө	ТЗУГ, СХОГ, ХШУДАГ	ТЗУХ, ГТАХ	ГМТ, ГБТА
5	Газрын тосны бүтээгдэхүүний импортын мэдээ, мян.тн (боомтын нэр, ААН-ээр)	7 хоног бүрийн 5 дахь өдрийн 15 цагаас өмнө, дараа сар, улирал бүрийн 05-ны дотор	ГТБГ, СХОГ	ГТБХ	-
6	Газрын тосны олборлолт, экспортын мэдээ, мян.бар, мян.тн (боомтын нэр, ААН-ээр)	7 хоног бүрийн 5 дахь өдрийн 15 цагаас өмнө	ГТБГ, СХОГ, ТЗУГ	ГТАХ	-
7	Газрын тосны бүтээгдэхүүний үлдэгдлийн мэдээ мян.тн /хот, аймаг, компаниар/	7 хоног бүрийн 5 дахь өдрийн 15 цагаас өмнө, дараа сар, улирал бүрийн 5-ны дотор	СХОГ, ГТБГ	ГТБХ	-
8	Шатахууны борлуулалтын бөөний болон жижиглэнгийн үнэ /аймаг, компаниар/	7 хоног бүрийн 5 дахь өдрийн 15 цагаас өмнө, дараа улирлын 05-ны дотор	СХОГ, ГТБГ	ГТБХ	-
9	Дэлхийн томоохон биржийн газрын тосны үнийн өөрчлөлт (ам.доллар)	7 хоног бүрийн 5 дахь өдрийн 15 цагаас өмнө, тухайн сар, улирал бүрийн 05-ны дотор	ГТБГ, СХОГ	ГТБХ	-
10	Газрын тосны бүтээгдэхүүний улсын болон компанийн нөөцийн мэдээ, тайлан	Жил бүрийн 1-р сарын 25-ны дотор	СХОГ, ГТБГ	ГТБХ	-
11	Газрын тосны эрэл, хайгуулын ажлын явцын мэдээ	Дараа сарын 10-ны дотор	СХОГ, ГТБГ	ГТХХ	-
12	Газрын тосны бүтээгдэхүүний агуулах,	Жил бүрийн 1-р сарын 25-ны дотор	СХОГ, ГТБГ	ГТБХ	-

	түгээх станцын техник, технологийн мэдээлэл, судалгаа.				
13	Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн мэдээлэл	Дараа 7 хоногийн 1 дахь өдөр 10 цагаас өмнө, Дараа сарын 05-ны дотор	СХОГ	ГУУКХ	-
14	Тусгай зөвшөөрлийн хөдөлгөөний мэдээ (шинээр олгосон, талбай буцаасан, шилжүүлсэн, цуцалсан, дуусгавар болсон, сунгуулсан, барьцаалсан, нөхөн олгосон, аймгаар, тусгай зөвшөөрөл эзэмшигчээр талбайн хэмжээгээр гэх мэт)	Дараа 7 хоногийн 1 дахь өдөр 10 цагаас өмнө, Дараа сарын 05-ны өдрийн дотор	СХОГ, ГБГ, УУБГ	ГУУКХ	-
15	Тусгай зөвшөөрөл эзэмшигч, бүтээгдэхүүн хуваах гэрээний оролцогч тал болон бусад этгээдийн зүгээс агентлагийн үйл ажиллагаатай холбогдуулан гаргасан гомдол, нэхэмжлэл болон шүүх хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцын талаарх мэдээ	Тухай бүр	СХОГ, ГБГ, УУБГ, ХХ, ХШУДАГ	ХЭЗХ	-
16	Зэсийн баяжмал (мян.тн) болон молибдений баяжмал (тн), металл агуулгаар (ААН-ээр)	Дараа сарын 05-ны дотор	СХОГ, УУБГ, ХУБГ	УУУТХ, ХУТТХ	-
17	Зэсийн баяжмал (мян.тн) болон молибдений исэл (тн) (ААН-ээр)	Дараа сарын 05-ны дотор	СХОГ, УУБГ, ХУБГ	УУУТХ	-
18	Молибдений баяжмал /үйлдвэрээр/	Дараа сарын 05-ны дотор	СХОГ, УУБГ, ХУБГ	УУУТХ	-
19	Мөнгөний олборлолт, баяжуулалт /үйлвэрлэл, экспорт/	Дараа сарын 05-ны дотор	СХОГ, УУБГ, ХУБГ	УУУТХ	-
20	Молибдений исэл, тн /үйлдвэрлэл, экспорт/	Дараа сарын 05-ны дотор	СХОГ, УУБГ, ХУБГ	ХУТТХ	-
21	Техникийн молибдений хүчлийн кальци, тн /үйлдвэрлэл, экспорт/	Дараа сарын 05-ны дотор	СХОГ, ХУБГ	ХУТТХ	-
22	Рений исэлдүүлсэн аммони, кг /үйлдвэрлэл, экспорт/	Дараа сарын 05-ны дотор	СХОГ, ХУБГ	ХУТТХ	-
23	Цахилгааны зэс утас, кабель бусад бүтээгдэхүүн, тн /үйлдвэрлэл, марк, экспорт, үйлдвэрээр/	Дараа сарын 05-ны дотор	СХОГ, ХУБГ	ХУТТХ	-
24	Хоёрдогч түүхий эд /зэс гууль, хөнгөн цагаан, хар тугалга тэдгээрийн хайлш/ боловсруулж хийсэн бэлдэц, цувимал болон цутгамал бүтээгдэхүүн, тн	Дараа сарын 05-ны дотор	СХОГ, ХУБГ	ХУТТХ	-
25	Ширэм, мян.тн /маркаар/	Дараа улирлын эхний сарын 05-ны дотор	СХОГ, ХУБГ	ХУТТХ	-

26	Металл бэлдэц болон бүтээгдэхүүн /үйлдвэр болон нэр төрлөөр/	Дараа сарын 05-ны дотор	СХОГ, ХУБГ	ХҮТТХ	-
27	Хүхрийн хүчил, тн /импортын мэдээ, үйлдвэрээр/	Дараа улирлын эхний сарын 05-ны дотор	СХОГ, ХУБГ	ХҮТТХ	-
28	Металлургийн кокс /импортын мэдээ, үйлдвэрээр/	Дараа улирлын эхний сарын 05-ны дотор	СХОГ, ХУБГ	ХҮТТХ	-
29	Алт олборлолт /аймгаар, тусгай зөвшөөрөл эзэмшигчээр/	Дараа сарын 05-ны дотор	СХОГ, УУБГ	УУУТХ	-
30	Төмрийн хүдрийн олборлолт, баяжуулалт мян.тн /уурхай, компаниар, үйлдвэрлэл, экспорт/	Дараа сарын 05-ны дотор	СХОГ, УУБГ	УУУТХ	-
31	Хайлуур жоншны хүдэр, баяжмал /уурхай, компаниар, үйлдвэрлэл, экспорт/	Дараа сарын 05-ны дотор	УУБГ, СХОГ	УУУТХ	-
32	Хайлуур жоншны хүдрийн олборлолт, экспорт, мян.тн (ААН-ээр)	Дараа сарын 05-ны дотор	УУБГ, СХОГ	УУУТХ	-
33	Цайрын баяжмалын олборлолт, экспорт, мян.тн (ААН-ээр)	Дараа сарын 05-ны дотор	УУБГ, СХОГ	УУУТХ	-
34	Гянтболдын баяжмалын олборлолт, экспорт, мян.тн (ААН-ээр)	Дараа улирлын эхний сарын 05-ны дотор	ХУБГ, УУБГ, СХОГ	УУУТХ	-
35	Уул уурхайн биологийн болон техникийн нөхөн сэргээлт /аймаг, тусгай зөвшөөрөл эзэмшигчээр/	Тухайн жилийн тайлангаар	СХОГ, УУБГ	УУУТХ, НСХ	-
36	Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох дүгнэлт гарсан талбайн мэдээлэл, га /аймаг, нөхөрлөл, бичил уурхайчдын тоо/	Дараа сарын 05-ны дотор	СХОГ, УУБГ	УУУТХ	-
37	Уул уурхайн бүтээгдэхүүн тус бүрээр олборлох, борлуулах, экспортод гаргах мэдээлэл	Тухайн жилийн тайлангаар	СХОГ, УУБГ	УУУТХ, НСХ	-
38	Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэж шийдвэрлэсэн ТЭЗҮ-ийн талаарх мэдээлэл	Дараа сарын 05-ны дотор	СХОГ, УУБГ, ХШУДАГ	УУХҮТ, НСХ	ГМТ, ГБТА
39	Ашигт малтмалын нөөцийн хөдөлгөөний мэдээ, тайлан	Тухайн жилийн тайлангаар	СХОГ, УУБГ, ГБГ	УУУТХ, НСХ	ТЗУХ
40	Улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжиж буй төслүүдийн улирлын тайлан.	Дараа улирлын эхний сарын 05-ны дотор	СХОГ, ГБГ, ХШУДАГ		ГСХ, ЭБСЭЗТХ
41	Улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжиж буй төслүүдийн сар бүрийн гүйцэтгэл.	Сар бүрийн 25-ны дотор	СХОГ, ГБГ, ХШУДАГ		ГСХ, ЭБСЭЗТХ
42	Улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэсэн геологийн судалгааны ажлын тайлан	Жилийн эцэст	СХОГ, ГБГ, ХШУДАГ		ТЗУХ
43	Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөл хуралдаанаар хэлэлцэгдсэн тайлан,	Улирал бүрийн 05-ны дотор	СХОГ, ГБГ, ХШУДАГ	АМХХ	ГМТ, ГБТА

	бүртгэгдсэн ашигт малтмалын нөөцийн мэдээ,				
44	Эрдэс түүхий эдийн стандарт зохиох төслийн мэдээ	Тухай бүр	СХОГ, ТЗУХ	УУУТБШТТЛ	-
45	Уулын ажлын төлөвлөгөө, тайлангийн мэдээ	Дараа сарын 05-ны дотор	СХОГ, УУБГ	УУУТХ, НСХ	-
46	Монгол улсын хилээр шинжилгээний дээж нэвтрүүлэхэд өгөх зөвшөөрлийн тодорхойлолт олгосон мэдээ	Дараа сарын 05-ны дотор	СХОГ, ГТБГ, УУБГ	УУУТХ, НСХ	ГСХ
47	Аймаг, сум орон нутгийн тусгай хэрэгцээ, нөөцөд авсан талбайн мэдээлэл	Дараа сарын 05-ны дотор	СХОГ, УУБГ, ГБГ	ГУУКХ	-
48	Салбарын гадаад хамтын ажиллагааны мэдээ тайланг ирүүлэх	Дараа сарын 05-ны дотор	ХШУДАГ, ГХАХ	ТЗУХ	ТЗУХ
49	Уул уурхайн болон геологийн салбарын боловсруулах үйлдвэрт нэвтрүүлж буй шинэ техник, технологи /МУ болон Дэлхийн хэмжээнд/	Тухай бүр	СХОГ, УУБГ, ГБГ	УУУТХ, НСХ, АМХХ	-
50	Уул уурхай болон газрын тосны экспортын мэдээ, мян.тн, мян.бар (бүтээгдэхүүн болон улсаар)	Дараа сарын 05-ны дотор	СХОГ, ГТБГ, УУБГ	УУУТХ, НСХ, ГТАХ	-
51	Гол нэр төрлийн ашигт малтмалын гадаадын болон дотоодын дундаж үнийн мэдээлэл	Дараа сарын 05-ны дотор	СХОГ, ГТБГ, УУБГ	ТЗУХ, УУУТХ, НСХ	-
52	Нүүрсний олборлолт, баяжуулалт, мян.тн /уурхай, компаниар, үйлдвэрлэл, экспорт/	Дараа 7 хоногийн 1 дахь өдрийн 10 цагаас цагаас өмнө, дараа сарын 5-ны дотор	СХОГ, УУБГ	НСХ	-
53	Хилийн боомтоор гарч буй экспортын нүүрсний чанарын мэдээ	7 хоног бүр	СХОГ, УУБГ	УУГТБШТТЛ	-
55	Дотоод аудитын чиглэлээр хийж гүйцэтгэсэн ажлын тайлан, мэдээ	Хагас жилээр, жилийн эцэст	ХШУДАГ	ХШҮСХ	ТЗУХ